

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧЛАГЫГ МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСЭГ, АЖЛЫН АЛБАНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ, 2012 ОНД НИЙЛҮҮЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮН, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

1.0. ӨМНӨХ ҮГ

Энэхүү баримт бичигт Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (цаашид “ОУИТБС” гэх)-ыг Монгол Улсад хэтийн төлөвлөгөөтэй, үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлэх стратеги, нийлүүлэх бүтээгдэхүүний төрөл, түүний дотор 2012 онд нийлүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгалаа.

2.0. ЭРХ ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭ

“Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачлагыг дэмжих тухай” Засгийн газрын 2006 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 1 дүгээр тогтоолын 1 дэх зүйлд “Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Ерөнхий сайд Тони Блейрийн санаачилсан Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачлагыг дэмжих нь зүйтэй гэж үзсүгэй” гэж заасан нь Монгол Улсад энэхүү санаачилга хэрэгжиж эхлэх гараа болсон юм. Монгол Улс ОУИТБС-ыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий олон талт Үндэсний зөвлөл, ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг 2006 оны эхнээс ажиллаж байна. Дэлхийн банкны Итгэлийн сангаас тусламж олгон, ОУИТБС-ыг хэрэгжүүлэх ихэнх зардлыг хариуцаж, түүний дотор орон тооны ажилтан бүхий Ажлын алба 2007 оноос байгуулагдан ажиллаж байна. ОУИТБС-ын Монгол Улсын 2006, 2007, 2008, 2009, 2010 оны нэгдсэн тайлан гаргаж, тайлангаас тайланд хамрагдах компанийн тоог нэмэгдүүлж, зөрүүг багасгаж ирлээ. Монгол Улс ОУИТБС-ын олон улсын баталгаажуулалтад 2009 онд орж, 2010 оны 10 дугаар сард санаачилгын шаардлагыг хангасан 4 дэх орон болсон юм. ОУИТБС-ын шаардлагыг хангасан орон болсон нь Монгол Улсын өмнө ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд илүү их шаардлага, шалгуурууд тавигдаж байна.

Монгол Улс ОУИТБС-ыг хэрэгжүүлэхдээ Засгийн газрын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль, Статистикийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдалтай холбоотой хуулиуд зэрэг хууль тогтоомжийн зэрэгцээ энэ асуудлаар Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, холбогдох сайд, газрын даргын тушаалууд гарган эрх зүйн орчноо бүрдүүлэн ажиллаж байна. Мөн ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд баримтлах бодлого, үйл ажиллагааны чиглэлээ Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлан мөрдөж байгаагийн зэрэгцээ жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган түүнээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

3.0 СТРАТЕГИЙН ҮНДСЭН ЗОРИЛТУУД

3.1. ОУИТБС-ын олон талт оролцогч талуудын алсын хараа

“Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах замаар иргэнд нээлттэй, авилгагүй, байгальд ээлтэй олборлох үйлдвэрлэл болон олон талт оролцогчдын хамтын ажиллагааг хөгжүүлэх, түүний эрх зүйн орчинг бүрдүүлсэн байх”.

3.2. ОУИТБС-ын олон талт оролцогч талуудын эрхэм зорилго, үндсэн зарчим

3.2.1. Монгол Улсын ОУИТБС-ын эрхэм зорилго нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын талаархи олон улсын дүрэм, Засгийн газрын бодлого, тэдгээрийн хэрэгжилтийг олон талт оролцогчдын хамтын ажиллагааны тэнцвэртэй байдлыг хангахад чиглэсэн цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, үйлчилгээгээр хангах замаар иргэнд нээлттэй, авилгагүй, байгальд ээлтэй олборлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх явдал мөн.

3.2.2. Монгол Улсын ОУИТБС нь дараахь үндсэн зарчим, үнэт зүйлийг үйл ажиллагаандаа эрхэмлэнэ:

Зарчим:

- Үндэсний хөгжлийн ашиг сонирхлыг эрхэмлэх;
- Хуулийг дээдэлж, үүргээ биелүүлэх;

- Зохистой удирдлагатай байхыг итгэл үнэмшил болгох;
- Орлогыг иргэдэд ил тод нээлттэй болгох;
- Хариуцлагатай байх;
- Олборлолтын орлогыг ил тод болгох;
- Засгийн газрын олборлох үйлдвэрлэлээс олсон материаллаг орлогыг ил тод болгох;
- Санхүүгийн орчныг сайжруулах;
- Хэрэглэхэд энгийн хялбар арга барилыг сонгох;
- Бүх талын хамтын шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлэх.

Үнэт зүйл:

- Үндэсний эв нэгдлийг хангах, олон талт оролцогчдын багаар ажиллах;
- Ардчилсан ёс, олон янз байхыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэлтэй хандах;
- Шударга ёс, тэгш, нэгдмэл байдлыг хангах;
- Эрх чөлөөг эрхэмлэх, санаачлагатай байх.

3.3. Орчны шинжилгээ

Давуу тал	Боломж
<ul style="list-style-type: none"> ❖ ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд анхнаас нь 3 талын тэгш оролцоог хангасан ❖ Дунд хугацааны бодлогын баримт бичигтэй ❖ Бодлогын гол гол баримт бичгүүд мөрдөгдөж байгаа ❖ 3 талын хамтын ажиллагааны санамж бичигтэй, мөн хамтран ажиллах арга барил бий болгосон ❖ Харилцааны бүхий хэлбэрийг ашигладаг ❖ Төлөвлөгөөтэй ажилладаг ❖ Санхүүгийн боломжууд нэмэгдэж байгаа ❖ Зохион байгууллалтын 3 бүтэцтэй, үүний дотор 3 хүнтэй ажлын албатай 	<ul style="list-style-type: none"> ❖ Олон улсын зохион байгуулалтын орчин бүрдсэн ❖ Санаачилга бүхий олон улсын иргэний нийгмийн болон компанийн туршлага, гадаад орнуудад хэрэгжүүлж байгаа практик ❖ Олон улсын банк, санхүүгийн байгууллагын дэмжлэг ❖ Олон улсын дүрэмтэй ❖ Иргэний нийгмийн байгууллага мэдээлэл сайтай ❖ Хариуцлагатай уул уурхайн хөдөлгөөн өрнөж байгаагийн дотор ОУИТБС орж байгаа
Сул тал	Аюул занал
<ul style="list-style-type: none"> ❖ Ихэнх ажил, үйлчилгээ орон нутаг, яам, агентлагийн үйл ажиллагааны урсгал үр дүн, тэдний санаачлагаас болж доголдог ❖ ҮЗ, АХ орон тооны бус тул хуралдаанд ажилтнууд орон ирдэг ❖ 1800 гаруй компанийн тайлан гаргах ажил их цаг шаардагдана ❖ Тайлан аудитаар баталгаажуулах тоо мэдээнд тулгуурладаг ❖ Засгийн газар солигдох бүрт бүрэлдэхүүн шинэчлэгддэг ❖ Компанийн болон төрийн захиргааны байгууллагын санхүүгийн ажилтнууд байнга солигдож байдаг ❖ Компаниудын хувьд гадаадын хөрөнгө оруулалттай компани, түүний дотор ОУИТБС-д нэгдээгүй орнуудын компани олон бий ❖ Тайлангийн зөрүүг шийдвэрлэх эрх зүйн орчин байхгүй ❖ Хууль эрх зүйн орчин тодорхой бус ❖ Хувь хүн, гишүүний идэвх санаачлага дээр ажил тогтож байгаа 	<ul style="list-style-type: none"> ❖ Олон ургалч үзлийн уулзвар дээр ажилладаг ❖ 3 талын харилцаанд ажлын арга барилаас шалтгаалж ойлгомжгүй байдал үүсч болзошгүй ❖ Мэдээллийг иргэн бүрт хүргэх орчин хангалтгүй ❖ Ажилтны санамсаргүй, хайхрамжгүй байдлаас улс болон салбарын бодлогод алдаа гарч болзошгүй ❖ Тогтсон тууштай санхүүжилт байхгүй ❖ Байгаль хамгаалах чиглэлийн иргэний зарим хөдөлгөөнүүд ОУИТБС-ын үйл ажиллагааг үгүйсгэдэг ❖ Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгууллагын нууцын зэрэглэлд байдаг ❖ ҮЗ, АХ-гийн хуралдааныг улирал, сар бүр тогтмолжуулах гэсэн санал бүхий гишүүд бий ❖ Сонирхлын бүлгүүдийн нөлөөнд автах

3.4. ОУИТБС-ын олон талт оролцогч талуудын стратегийн зорилт

ОУИТБС-ын олон талт оролцогч талуудын 2012-2014 оны үйл ажиллагааны стратегийн зорилт:

1. ОУИТБС-ын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, олон улсын дүрмээр тавьсан шаардлагуудыг биелүүлэх;
2. Монгол Улсын ОУИТБС-ын жил бүрийн тайланд хамрагдах компанийн тоог нэмэгдүүлэх, тайлангийн зөрүүг багасгах;
3. Олон талт оролцогчдын төлөөлөл бүхий Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулах;
4. ОУИТБС-ын оролцогчдын чадавхийг бэхжүүлэх;
5. ОУИТБС-ын зарчим, шалгуур болон Монгол Улсын ОУИТБС-ын тайланг ил тод мэдээлэх;
6. Хамтын ажиллагааг өргөжүүлэх.

3.5. Үйл ажиллагааны хамрах хүрээ

ОУИТБС-ын олон талт оролцогч талуудын үйл ажиллагааны хамрах хүрээ нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, оролцогч талуудын хамтран тохирсон бодлогын хүрээнд байна. Энэ хүрээнд ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн зөвлөлгөө, үйлчилгээ, дэмжлэг үзүүлнэ. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, санамж бичиг, олон улсын дүрэм, эрх зүйн бусад баримт бичгийн хүрээнд оролцогч Гурван тал, яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, компани, иргэний нийгэм, тэдгээрийн удирдлагатай харилцаж, мэргэжил арга зүйн зөвлөлгөө, дэмжлэг, оролцогч талуудын дундын зохицуулалтаар хангана.

3.6. Нэн тэргүүнд нийлүүлэх бүтээгдэхүүний ангилал

Бүтээгдэхүүний анги	Бүтээгдэхүүн	Дэд бүтээгдэхүүн
Бүтээгдэхүүн анги 1. Бодлогын зөвлөлгөө	Бүтээгдэхүүн 1.1. Эрх зүйн орчинг боловсронгуй болгох зөвлөлгөө, санал	I. ОУИТБС-ын эрх зүйн орчинг боловсронгуй болгох санал, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төсөл II. Сайд, газрын даргын тушаалын төсөл, холбогдох баримт материал, судалгаа, танилцуулга III. Үндэсний хэмжээнд баримтлах бодлогын баримт бичгийн төсөл IV. Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн ажиллах журам, харилцааны баримт бичиг төсөл
	Бүтээгдэхүүн 1.2. Тайлан гаргах маягт, заавар	I. Тайлан гаргах маягт, зааврын төсөл II. Маягт, заавар баталсан тушаал, шийдвэр, III. Бусад шийдвэр
Бүтээгдэхүүн анги 2. Монгол Улсын ОУИТБС-ын жил бүрийн нэгдсэн тайлангууд	Бүтээгдэхүүн 2.1. Тайлангууд	I. Тайлан гаргах аудитын концерциум зарлах шийдвэр, сонгон шалгаруулалт
		II. Байгуулсан гэрээнүүд
		III. Засгийн газар, компанийн ОУИТБ-ын тайлангууд
		IV. Монгол Улсын ОУИТБС-ын нэгдсэн тайлангууд
		V. Хураангуй тайлангууд
Бүтээгдэхүүн анги 3 Мэргэжил арга зүйн зөвлөлгөө, дэмжлэг	Бүтээгдэхүүн 3.1. Үндэсний зөвлөлийн хуралдаанд оруулах асуудлын төсөл	I. Хэлэлцэх асуудал, дотоод журам
		II. Хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл
		III. Хуралдааны шийдвэр
	Бүтээгдэхүүн 3.2. Ажлын хэсгийн хуралдаанд оруулах асуудлын төсөл	I. Хэлэлцэх асуудал, дотоод журам
		II. Хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл
		III. Хуралдааны шийдвэр
	Бүтээгдэхүүн 3.3. Ажлын албаны зөвлөлгөө, дэмжлэг	I. Танилцуулга
		II. Санал
		III. Гишүүдэд хүргэх мэдээлэл
Бүтээгдэхүүн анги 4 Оролцогч талуудын чадавхи	Бүтээгдэхүүн 4.1. Сургалт	I. Төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт
		II. Компанийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад зориулсан сургалт
		III. Оролцогч талуудын төлөөлөлд зориулсан сургалт
	Бүтээгдэхүүн 4.2. Семинар, төрөлжсөн уулзалт	I. Олон талт оролцогчдын семинар
		II. Бус, орон нутагт зохиосон семинар, уулзалт
		III. Бусад семинар, уулзалт
Бүтээгдэхүүн анги 5 Сурталчилгаа	Бүтээгдэхүүн 5.1. Веб сайтын үйл ажиллагаа	I. Веб сайтын материалын шинэчлэл
		II. Бусад веб сайтад тавьсан материал
	Бүтээгдэхүүн 5.2. хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хийх сурталчилгаа	I. Сонин, хэвлэлд тавьсан мэдээлэл, ярилцлага
		II. Хэвлэлийн бага хурал
		III. Телевизийн мэдээ, сурталчилгаа
		IV. Сайтуудад тавьсан мэдээ
Y. Хэвлэмэл материал, бусад сурталчилгаа		
Бүтээгдэхүүн анги 6 Хамтын ажиллагаа	Бүтээгдэхүүн 6.1. Оролцогч талуудын хамтын ажиллагаа	I. Оролцогч 3 талын хамтын ажиллагаа
		II. Яам, агентлагтай хамтын ажиллагаа
		III. Нутгийн захиргааны байгууллагын хамтын ажиллагаа
	Бүтээгдэхүүн 6.2. гадаад хамтын ажиллагаа	I. Олон улсын Нарийн бичгийн дарга нарын газрын хамтын ажиллагаа
		II. Санхүүжүүлэгч банк, санхүүгийн байгууллагын хамтын ажиллагаа
III. ОУИТБС-ын хэрэгжүүлэгч орнуудтай хийсэн хамтын ажиллагаа		

4.0. ТӨСВИЙН ЖИЛ-2012 ОНД НИЙЛҮҮЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮН

Бүтээгдэхүүний анги 1: Бодлогын зөвлөлгөө

Томъ олол: Энэхүү бүтээгдэхүүний анги нь хууль тогтоомж, шийдвэрийн талаар баримтлах зарчмыг тодорхойлох, зөвлөлгөө өгөх зорилго бүхий чиглэл гаргах, эсхүл хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, сайдын тушаалын төсөл боловсруулах, ОУИТБС-ын хөгжлийн бодлогын зөвлөлгөө зэрэг ажил, үйл ажиллагааг хамарна.

Тоо хэмжээ, хугацаа: Энэхүү бүтээгдэхүүний ангид нийт 2 бүтээгдэхүүн орох бөгөөд жил бүрийн бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсанаар нийлүүлнэ.

Чанар: Энэхүү бүтээгдэхүүний ангид багтах бүтээгдэхүүнд чанарын дараахь шаардлага тавина:

- ❖ Бодлогын зөвлөлгөө, хууль тогтоомж, шийдвэр, бодлогын баримт бичгийн төсөл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, Засгийн газрын бодлоготой уялдсан, хөрөнгийн баталгаатай, хэл найруулгын хувьд оновчтой томъёологдсон байна.

Бүтээгдэхүүн 1.1. Эрх зүйн орчинг боловсронгуй болгох зөвлөлгөө, санал

Томъёолол: Энэхүү бүтээгдэхүүн нь ОУИТБС-ын талаар баримтлах зарчмыг тодорхойлох, хууль тогтоомж, Засгийн газрын бодлого, төсөвт нийцсэн байдлаар өгөх зөвлөлгөө буюу төслийг боловсруулах, санал бэлтгэх үйл ажиллагааг хамарна.

Шалгуур үзүүлэлт		2012 онд хүрэх түвшин
Тоо хэмжээ: I. ОУИТБС-ын эрх зүйн орчинг боловсронгуй болгох санал, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төсөл II. Сайд, газрын даргын тушаалын төсөл, холбогдох баримт материал, судалгаа, танилцуулга III. Үндэсний хэмжээнд баримтлах бодлогын баримт бичгийн төсөл IV. Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн ажиллах журам, харилцааны баримт бичиг төсөл		2-5 багц 1-3 Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсанаар Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсанаар
Чанар:	Боловсруулсан асуудал нь ОУИТБС-ын зарчим, шалгуур, олон улсын дүрэм, Монгол Улсын хууль тогтоомж, шийдвэр боловсруулах шаардлагын дагуу бүрдэл болсон байна.	
Хугацаа:	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд	
Хүн/өдөр		
Өртөг	Хандивлагч .. мянган төгрөг	

Бүтээгдэхүүн 1.2. Тайлан гаргах маягт, заавар

Томъёолол: Энэхүү бүтээгдэхүүнд ОУИТБС-ын тайланг Засгийн газрын байгууллагууд, уул уурхай, газрын тосны хайгуул, ашиглалт явуулдаг компаниудын тайлан гаргах үзүүлэлт, гаргах зааврыг бүрэн тусгасан маягт, зааврын төсөл, холбогдох танилцуулга, тушаалын төсөл зэрэг тайлан гаргах ажлыг боловсронгуй болгох үйл ажиллагаа, ажил, үйлчилгээ хамарна.

Шалгуур үзүүлэлт		2012 онд хүрэх түвшин
Тоо хэмжээ: I. Тайлан гаргах маягт, зааврын төсөл II. Маягт, заавар баталсан тушаал, шийдвэр, III. III. Бусад шийдвэр		ЕСБХБ-ны зөвлөмж, тайлан Энэ онд батлахгүй Нэмэлт шаардлага гарвал
Чанар:	Маягт, заавар нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, ойлгомжтой байна.	
Хугацаа:	Ажлын хэсгээс өгсөн хугацаанд багтаана.	
Хүн/өдөр	..	
Өртөг	Хандивлагч ... мянган төгрөг	

Бүтээгдэхүүний анги 2: Монгол Улсын ОУИТБС-ын 2011 оны нэгдсэн тайлан

Томъёолол: Энэхүү бүтээгдэхүүний анги нь Монгол Улсын ОУИТБС-ын 2011 оны нэгдсэн тайлан гаргах аудитын консерциум сонгон шалгаруулах удирдамж, сонгон шалгаруулалт явуулах шийдвэр, сонгон шалгаруулалтын үнэлгээний хорооны үйл ажиллагаа, сонгон шалгарсан аудитын консерциумтай гэрээ байгуулах, Монгол Улсын ОУИТБС-ын 2011 оны нэгдсэн тайлан гаргах зэрэг ажил, үйл ажиллагаа, үйлчилгээг хамарна.

Тоо хэмжээ, хугацаа: Энэхүү бүтээгдэхүүний ангид нийт 1 бүтээгдэхүүн орох бөгөөд жил бүрийн бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсанаар нийлүүлнэ.

Чанар: Энэхүү бүтээгдэхүүний ангид багтах бүтээгдэхүүнд чанарын дараахь шаардлага тавина:

- ❖ ОУИТБС-ын олон улсын дүрмийн шаардлага хангагдсан байна.
- ❖ Монгол Улсын ОУИТБС-ын 2011 оны нэгдсэн тайлан нь аудитын консерциум сонгон шалгаруулах удирдамжийн шаардлагыг хангасан байна.
- ❖ Тайлангийн зөвлөмж нь хэрэгжиж болохуйц байна.
- ❖ Монгол Улсын ОУИТБС-ын 2011 оны тайлан нь тоо баримт баталгаатай, үг хэллэг оновчтой томъёологдсон байна.
- ❖ Монгол Улсын ОУИТБС-ын 2011 оны тайлангийн хураангуй хувилбарыг аймаг, нийслэл, ашигт малтмалын төрлөөр нь гаргана.

Бүтээгдэхүүн 2.1. Тайлан

Томъёолол: Энэхүү бүтээгдэхүүн нь Монгол Улсын ОУИТБС-ын 2011 оны нэгдсэн тайлан гаргах аудитын консерциум сонгон шалгаруулах удирдамж, сонгон шалгаруулалт явуулах шийдвэр, сонгон шалгаруулалтын үнэлгээний хорооны үйл ажиллагаа, сонгон шалгарсан аудитын консерциумтай гэрээ байгуулах, Монгол Улсын ОУИТБС-ын 2011 оны нэгдсэн тайлан гаргах зэрэг ажил, үйл ажиллагаа, үйлчилгээг хамарна.

Шалгуур үзүүлэлт		2012 онд хүрэх түвшин
Тоо хэмжээ: I. Тайлан гаргах аудитын консерциум зарлах шийдвэр, сонгон шалгаруулалт II. Байгуулсан гэрээ III. Засгийн газар, компанийн ОУИТБС-ын тайлан IV. Монгол Улсын ОУИТБС-ын нэгдсэн тайлан V. Хураангуй тайлангууд		1 1 2 талын багц тайлан 1 гүйцэтгэлээр
Чанар:	<ul style="list-style-type: none"> ❖ Аудитын консерциум сонгон шалгаруулах удирдамж, шийдвэр нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, олон улсын дүрмийн шаардлага хангасан, хөрөнгийн баталгаатай, үг хэллэг оновчтой томъёологдсон байна. ❖ Гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна. 	

	<ul style="list-style-type: none"> ❖ Монгол Улсын ОУИТБС-ын 2011 оны тайлан нь тоо баримт баталгаатай, үг хэллэг оновчтой томъёологдсон байна. ❖ Монгол Улсын ОУИТБС-ын 2011 оны тайлангийн хураангуй хувилбарыг аймаг, нийслэл, ашигт малтмалын төрлөөр нь гаргаж хэрэглэгчдэд хүргэсэн байна.
Хугацаа:	-Сонгон шалгаруулалтын удирдамж, шийдвэр нь хууль тогтоомжид заасан хугацаанд нийцсэн байна. -Тайлан гаргах ажил, үйлчилгээ нь гэрээнд заасан хугацааг баримтална.
Хүн/өдөр	..
Өртөг	Улсын төсөв 200000.0 мянган төгрөг

Бүтээгдэхүүний анги 3: Мэргэжил, арга зүйн зөвлөлгөө

Томъёолол: Энэ бүтээгдэхүүний ангид ОУИТБС-ыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөл, ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн хуралдаан, хуралдаанд бэлтгэх, хуралдаанаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, хуралдааны шийдвэр, Ажлын албаны зөвлөгөө, дэмжлэг зэрэг мэргэжил арга зүйн зөвлөлгөө, дэмжлэгээр хангах зэрэг асуудлууд багтана.

Тоо хэмжээ, хугацаа: Энэхүү бүтээгдэхүүний ангид нийт 3 бүтээгдэхүүн орох бөгөөд жил бүрийн бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдснаар нийлүүлнэ.

Чанар: Энэхүү бүтээгдэхүүний ангид багтах бүтээгдэхүүнд чанарын дараахь шаардлага тавина:

- ❖ Мэргэжил арга зүйн зөвлөлгөө нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөл, ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэгдсэн байна.
- ❖ Хэлэлцүүлэх асуудал, мэргэжил арга зүйн зөвлөлгөө нь цаг үеэ олсон байна.

Бүтээгдэхүүн 3.1. Үндэсний зөвлөлийн хуралдаанд оруулах асуудлын төсөл

Томъёолол: Энэхүү бүтээгдэхүүнд ОУИТБС-ыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн хуралдаанд бэлтгэх, зохион байгуулах, хуралдуулах, шийдвэрийг албажуулахад чиглэсэн ажил, үйл ажиллагаа багтана.

Шалгуур үзүүлэлт	2012 онд хүрэх түвшин
Тоо хэмжээ: I. Хэлэлцэх асуудал, дотоод журам II. Хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл III. Хуралдааны шийдвэр	3 багц үйлчилгээ 3 багц үйлчилгээ 3 багц үйлчилгээ
Чанар:	Хуралдааны бэлтгэлийг сайн хангасан, хэлэлцүүлэх асуудал нь бүрэн боловсрогдсон байх бөгөөд Үндэсний зөвлөлд үзүүлэх дэмжлэг, үйлчилгээ нь дотоод ажилд нь оролцохгүй, зөвхөн оролцогч талуудын итгэл үнэмшил, Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны түвшинд нэгдмэл байдлаар уялдуулах чиглэлтэй байна.
Хугацаа:	Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөгөөнд заасан хугацаанд бэлтгэлийг хангах
Хүн/өдөр	..
Өртөг	Улсын төсөв 2450.0 мянган төгрөг

Бүтээгдэхүүн 3.2. Ажлын хэсгийн хуралдаанд оруулах асуудлын төсөл

Томъёолол: Энэхүү бүтээгдэхүүнд ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн хуралдаанд бэлтгэх, зохион байгуулах, хуралдуулах, шийдвэрийг албажуулахад чиглэсэн ажил, үйл ажиллагаа багтана.

Шалгуур үзүүлэлт	2012 онд хүрэх түвшин
Тоо хэмжээ: I. Хэлэлцэх асуудал, дотоод журам II. Хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл III. Хуралдааны шийдвэр	5 багц үйлчилгээ 5 багц үйлчилгээ 5 багц үйлчилгээ
Чанар:	Хуралдааны бэлтгэлийг сайн хангасан, хэлэлцүүлэх асуудал нь бүрэн боловсрогдсон байх бөгөөд Ажлын хэсэгт үзүүлэх дэмжлэг, үйлчилгээ нь дотоод ажилд нь оролцохгүй, зөвхөн оролцогч талуудын итгэл үнэмшил, Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны түвшинд нэгдмэл байдлаар уялдуулах чиглэлтэй байна.
Хугацаа:	Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөгөөнд заасан хугацаанд бэлтгэлийг хангах
Хүн/өдөр	..
Өртөг	Улсын төсөв 4000.0 мянган төгрөг

Бүтээгдэхүүн 3.3. Ажлын албаны зөвлөгөө, дэмжлэг

Томъёолол: Энэхүү бүтээгдэхүүнд ОУИТБС-ын өдөр тутмын ажлыг эрхлэн хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагаа, Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүдэд өгөх зөвлөгөө, дэмжлэг зэрэг ажил, үйл ажиллагаа багтана.

Шалгуур үзүүлэлт	2012 онд хүрэх түвшин
Тоо хэмжээ: I. Танилцуулга II. Санал III. Гишүүдэд хүргэх мэдээлэл IV. Арга зүйн зөвлөгөө V. Аймаг, нийслэлд үзүүлсэн дэмжлэг	Гүйцэтгэлээр Гүйцэтгэлээр Гүйцэтгэлээр Гүйцэтгэлээр Гүйцэтгэлээр
Чанар:	Ажлын албаны өдөр тутмын зөвлөгөө дэмжлэг, үйл ажиллагаа нь ОУИТБС-ын 2012 оны бүтэгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг ханган биелүүлэх, олон улсын дүрмийн шаардлагыг хангахад чиглэгдсэн, оролцогч талуудын төлөөлөл, нутгийн захиргааны байгууллага болон компани, иргэний нийгмийн байгууллагыг нэгдмэл байдлаар уялдуулах чиглэлтэй байна.

Хугацаа:	Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөгөөнд заасан хугацаанд
Хүн/өдөр	..
Өртөг	Хандивлагч 52,1 мянган ам. доллартай тэнцэх төгрөг

Бүтээгдэхүүн анги 4. Оролцогч талуудын чадавхи

Томъёолол: Энэхүү бүтээгдэхүүний анги нь Засгийн газар, компани, иргэний нийгмийн оролцогч талуудын чадавхийг сайжруулахад чиглэсэн сургалт, семинар, төрөлжсөн уулзалт зэрэг үйл явцыг хамарсан ажил, үйл ажиллагаа багтаана.

Тоо хэмжээ, хугацаа: Энэхүү бүтээгдэхүүний ангид нийт 2 бүтээгдэхүүн орох бөгөөд жил бүрийн бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдснаар нийлүүлнэ.

Чанар: Энэ бүтээгдэхүүний ангид багтах бүтээгдэхүүнд дараахь шаардлага тавигдана:

- ❖ Сургалт, семинар, төрөлжсөн уулзалт нь урьдчилан бэлтгэлийг сайтар хангасан, оролцогчдын санаачлага, идэвхид тулгуурласан, тэдэнд өгөөжтэй арга хэлбэрийг сонгосон байна.

Бүтээгдэхүүн 4.1. Сургалт

Томъёолол: Энэхүү бүтээгдэхүүнд ОУИТБ-ыг хэрэгжүүлэх чиглэлээр оролцогч талуудын чадавхийг сайжруулахад чиглэсэн сургалт явуулах дэмжлэг үйлчилгээ багтана.

Шалгуур үзүүлэлт		2012 онд хүрэх түвшин
Тоо хэмжээ:		
I.Төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт		1
II. Компанийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад зориулсан сургалт		1
III.Оролцогч талуудын төлөөлөлд зориулсан сургалт		1
Чанар:	Сургалт нь урьдчилан бэлтгэлийг сайтар хангасан, оролцогчдын санаачлага, идэвхид тулгуурласан, тэдэнд өгөөжтэй арга хэлбэрийг сонгосон байна.	
Хугацаа:	Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөгөөнд заасан хугацаанд	
Хүн/өдөр	..	
Өртөг	Хандивлагч 16000.0 мянган ам.доллартай тэнцэх төгрөг, улсын төсөв 5000.0 мянган төгрөг	

Бүтээгдэхүүн 4.2. Семинар, төрөлжсөн уулзалт

Томъёолол: Энэхүү бүтээгдэхүүнд ОУИТБ-ыг хэрэгжүүлэх чиглэлээр оролцогч талуудын чадавхийг сайжруулахад чиглэсэн сургалт явуулах дэмжлэг үйлчилгээ багтана.

Шалгуур үзүүлэлт		2012 онд хүрэх түвшин
Тоо хэмжээ:		
I.Олон талт орлоцогчдын семинар		1
II.Бүс, орон нутагт зохион семинар, уулзалт		3
III.Бусад семинар, уулзалт		гүйцэтгэлээр
Чанар:	Бүс, орон нутагт зохиосон семинар, уулзалт нь урьдчилан бэлтгэлийг сайтар хангасан, оролцогчдын санаачлага, идэвхид тулгуурласан, тэдэнд өгөөжтэй арга хэлбэрийг сонгосон байна.	
Хугацаа:	Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөгөөнд заасан хугацаанд	
Хүн/өдөр	..	
Өртөг	Хандивлагч 11000.0 мянган ам.доллартай тэнцэх төгрөг, улсын төсөв 5000.0 мянган төгрөг	

Бүтээгдэхүүн анги 5. Сурталчилгаа

Томъёолол: Энэхүү бүтээгдэхүүний анги нь Засгийн газар, компани, иргэний нийгмийн оролцогч талууд ОУИТБС-ын зарчим, шалгуур, ОУИТБС-ыг Монгол Улсад хэрэгжүүлж байгаа ажлын явц, үр дүн, тайлан, төлөвлөгөөний биелэлт зэрэг үйл ажиллагааг нийтэд хүргэх, мэдээлэхэд чиглэсэн сурталчилгааны бүхий л арга хэлбэрийг ашиглан явуулж байгаа үйл явцыг хамарсан ажил, үйл ажиллагаа багтаана.

Тоо хэмжээ, хугацаа: Энэхүү бүтээгдэхүүний ангид нийт 2 бүтээгдэхүүн орох бөгөөд жил бүрийн бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдснаар нийлүүлнэ.

Чанар: Энэ бүтээгдэхүүний ангид багтах бүтээгдэхүүнд дараахь шаардлага тавигдана:

- ❖ ОУИТБС-ын хэрэгжилтийн явц, үр дүнгийн сурталчилгаа нь урьдчилан бэлтгэлийг сайтар хангасан, хэрэглэгчдэд хүртээмжтэй, өгөөжтэй арга хэлбэрийг сонгосон байна.

Бүтээгдэхүүн 5.1. Веб сайтын үйл ажиллагаа

Томъёолол: Энэхүү бүтээгдэхүүнд ОУИТБС-ын Ажлын албаны веб сайтыг байнга шинэчлэх, нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй мэдээллийг байрлуулах, мэдээлэхэд чиглэсэн дэмжлэг үйлчилгээ багтана.

Шалгуур үзүүлэлт		2012 онд хүрэх түвшин
Тоо хэмжээ:		

I.Веб сайтын материалын шинэчлэл II.Бусад байгууллагын веб сайтад тавьсан материал III.Веб хуудсаа сайжруулах, эсхүл шинэчлэх санал	Байнга 2-оос доошгүй Гүйцэтгэлээр
Чанар:	Веб сайтын мэдээлэл нь байнга баяжиж, хандагчдын санал, хүсэлтэд тулгуурласан, тэдэнд өгөөжтэй арга хэлбэрийг сонгосон байна. Баяжилт нь байнгын, тогтмол, мэдээлэл нь товч тодорхой байна.
Хугацаа:	Өдөр тутам
Хүн/өдөр	..
Өртөг	Хандивлагч 2000 мянган ам.доллартай тэнцэх төгрөг

Бүтээгдэхүүн 5.2. Хэвлэл, мэдээлийн хэрэгслээр хийх сурталчилгаа

Томъёолол: Энэхүү бүтээгдэхүүнд ОУИТБ-ыг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, хурал, сургалт, семинар, боловсруулсан материал, оролцогч талуудын үйл ажиллагааны явц, үр дүнг сурталчлахад чиглэсэн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хийсэн сурталчилгааны тоо хэмжээ, материалыг багтана.

Шалгуур үзүүлэлт	2012 онд хүрэх түвшин
Тоо хэмжээ: I.Сонин хэвлэлд тавьсан мэдээлэл, ярилцлага II.Хэвлэлийн бага хурал III.телевизийн мэдээ, сурталчилгаа IV.Сайтуудад тавьсан мэдээ V.Хэвлэмэл материал, бусад сурталчилгаа	Сар бүр 1 багц 3 багцаас доошгүй Сар бүр 1 багц Сар бүр 1 багц гүйцэтгэлээр
Чанар:	Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хийх сурталчилгаа нь иргэдийн эрэлт, хэрэгцээ, санал, хүсэлтэд тулгуурласан, тэдэнд өгөөжтэй арга хэлбэрийг сонгосон байна.
Хугацаа:	Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөгөөнд заасан хугацаанд
Хүн/өдөр	..
Өртөг	Хандивлагч 28000 мянган ам.доллартай тэнцэх төгрөг

Бүтээгдэхүүн анги 6. Хамтын ажиллагаа

Томъёолол: Энэхүү бүтээгдэхүүний анги нь ОУИТБС-ын оролцогч талуудын хамтын ажиллагаа, гадаад хамтын ажиллагааны чиглэлээр төлөвлөсөн асуудал, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, түүний арга хэлбэр, харилцааны баримт бичгийг хэрэгжүүлсэн байдал зэрэг үйл явцыг хамарсан ажил, үйл ажиллагаа багтаана.

Тоо хэмжээ, хугацаа: Энэхүү бүтээгдэхүүний ангид нийт 2 бүтээгдэхүүн орох бөгөөд жил бүрийн бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдснаар нийлүүлнэ.

Чанар: Энэ бүтээгдэхүүний ангид багтах бүтээгдэхүүнд дараахь шаардлага тавигдана:

- ❖ ОУИТБС-ыг хэрэгжүүлэх чиглэлээр хамтын ажиллагаа нь урьдчилан бэлтгэлийг сайтар хангасан, оролцогч талуудад хүртээмжтэй, өгөөжтэй арга хэлбэрийг сонгосон байна.

Бүтээгдэхүүн 6.1. Оролцогч талуудын хамтын үйл ажиллагаа

Томъёолол: Энэхүү бүтээгдэхүүнд ОУИТБС-ыг хэрэгжүүлэх чиглэлээр оролцогч бүхий талуудын хамтын ажиллагааг өргөтгөх, үр дүнг сайжруулахад чиглэсэн ажил, арга хэмжээ, дэмжлэг үйлчилгээг багтаана.

Шалгуур үзүүлэлт	2012 онд хүрэх түвшин
Тоо хэмжээ: I.Оролцогч 3 талын хамтын ажиллагаа II.Яам, агентлагтай хамтын ажиллагаа III.Нутгийн захиргааны байгууллагын хамтын ажиллагаа	Байнга, гүйцэтгэлээр Байнга, гүйцэтгэлээр Байнга, гүйцэтгэлээр
Чанар:	Оролцогч талуудын хамтын ажиллагаа нь тогтмолжсон, арга хэлбэрийн хувьд баяжсан, оролцогчдын санал, санаачлагад тулгуурласан, тэдэнд өгөөжтэй арга хэлбэрийг сонгосон байна.
Хугацаа:	Өдөр тутам
Хүн/өдөр	..
Өртөг	.. мянган төгрөг

Бүтээгдэхүүн 6.2. Гадаад хамтын ажиллагаа

Томъёолол: Энэхүү бүтээгдэхүүнд ОУИТБ-ыг хэрэгжүүлэх чиглэлээр олон улсын байгууллага, санхүүжүүлэгч банк, санхүүгийн байгууллага, гадаад оронтой харьцах хамтын ажиллагаа, үйл ажиллагаагаа тайлагнах, мэдээлэх, ажлын үр дүнг сурталчлахад чиглэсэн ажил, арга хэмжээ, дэмжлэг үйлчилгээг багтаана.

Шалгуур үзүүлэлт	2012 онд хүрэх түвшин
Тоо хэмжээ: I.Олон улсын Нарийн бичгийн дарга нарын газрын хамтын ажиллагаа II.Санхүүжүүлэгч банк, санхүүгийн байгууллагын хамтын ажиллагаа III.ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч орнуудтай хийсэн хамтын ажиллагаа	Байнга, гүйцэтгэлээр Байнга, гүйцэтгэлээр Шаардлагатай үед, гүйцэтгэлээр
Чанар:	Гадаад хамтын ажиллагаа нь ОУИТБС-ын хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар мэдээлэл солилцох, арга

	зүйн зөвлөгөө авах, харилцан туршлага солилцоход чиглэсэн ажил, үйл ажиллагааны үр дүнтэй, чадавхи бэхжүүлэх өгөөжтэй байна.
Хугацаа:	Тогтмол
Хүн/өдөр	..
Өртөг	.. мянган төгрөг

5.0. Бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга зам

Бизнес төлөвлөгөөг ОУИТБС-ыг хэрэгжүүлэх 2012 оны бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөгөөр хэрэгжүүлнэ.

6.0. Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтэд тавих хяналт

Бизнес төлөвлөгөө болон ОУИТБС-ыг хэрэгжүүлэх 2012 оны бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөний биелэлтийг Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэнэ дүгнэж байна. Оролцогч аль нэг талын саналаар шаардлагатай бол бизнес төлөвлөгөө, ОУИТБС-ыг хэрэгжүүлэх 2012 оны бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөний биелэлтийг шалгаж болно.